


МӨНГӨНИЙ ТОЙМ

(2016 оны 3 дугаар сар)



МӨНГӨ, САНХҮҮГИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТҮҮД


	2014			2015			2016		
	12-р сар	2-р сар	3-р сар	6-р сар	9-р сар	12-р сар	1-р сар	2-р сар	3-р сар
M2 мөнгө, тэрбум ₮	10,635.8	10,230.5	9,903.7	10,041.3	9,934.5	10,050.2	9,850.8	10,015.0	10,113.7
сарын өөрчлөлт, %	7.1	-0.8	-3.2	2.0	-0.3	2.5	-2.0	1.7	1.0
жилийн өөрчлөлт, %	12.5	3.9	-0.5	-0.7	-1.4	-5.5	-4.5	-2.1	2.1
Бусад хадгаламж, тэрбум ₮	8,819.1	8,643.7	8,457.6	8,377.0	8,320.9	8,364.8	8,242.7	8,492.0	8,530.0
сарын өөрчлөлт, %	7.0	-1.1	-2.2	2.7	0.5	1.4	-1.5	3.0	0.4
жилийн өөрчлөлт, %	19.8	6.8	3.0	1.6	1.0	-5.2	-5.6	-1.8	0.9
Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө, тэрбум ₮	809.7	775.9	702.8	755.8	767.9	706.7	713.8	655.5	658.6
сарын өөрчлөлт, %	5.3	5.9	-9.4	-4.8	-0.8	-0.5	1.0	-8.2	0.5
жилийн өөрчлөлт, %	-3.7	2.5	-12.3	-12.1	-7.2	-12.7	-2.5	-15.5	-6.3
Нөөц мөнгө, ₮	3,426.5	2,748.0	2,468.5	2,352.2	2,410.1	2,459.6	2,310.7	2,308.4	2,360.7
сарын өөрчлөлт, %	27.9	-3.9	-10.2	-2.4	-14.7	17.9	-6.1	-0.1	2.3
жилийн өөрчлөлт, %	2.7	-12.2	-21.1	-18.4	-14.7	-28.2	-19.2	-16.0	-4.4
Санхүүгийн байгууллагуудын зээлийн үлдэгдэл, тэрбум ₮	16,604.7	16,539.2	17,074.2	17,194.2	17,829.8	17,944.0	18,085.9	18,161.0	18,443.0
сарын өөрчлөлт, %	2.7	1.2	3.2	0.9	1.2	0.5	0.8	0.4	1.6
жилийн өөрчлөлт, %	31.9	24.1	22.9	14.6	12.2	8.1	10.7	9.8	11.5
Хадгаламжийн байгууллагуудын зээлийн үлдэгдэл, тэрбум ₮	12,502.5	12,176.9	12,271.4	11,947.7	11,938.5	11,695.8	11,783.0	11,628.2	11,827.5
сарын өөрчлөлт, %	-1.2	0.7	0.8	-1.9	0.8	-1.6	0.7	-1.3	1.7
жилийн өөрчлөлт, %	16.1	9.2	7.8	-2.9	-5.3	-6.5	-2.5	-4.5	-3.6
Чанаргүй зээл/Хадгаламжийн байгууллагуудын зээл, хувиар	5.00	5.48	5.73	6.48	7.14	7.44	7.59	7.84	8.18
Чанаргүй зээл/Хадгаламжийн байгууллагуудын зээл, хувиар (Хадгаламж, Зоос банкныг хассанаар)	3.10	3.56	3.90	4.60	5.25	5.53	5.69	5.91	6.30
Хуу									
Хадгаламжийн ЖДХ	12.5	12.8	12.9	12.9	13.1	13.3	13.5	13.5	13.3
Зээлийн ЖДХ*	19.5	19.0	19.1	19.8	18.7	19.1	19.7	20.1	19.7
Монголбанкны ҮТХ зээлийг оруулсан ЖДХ*	16.9	18.0	17.6	18.2	17.6	18.3	19.1	19.1	17.9
Ипотекийн зээлийн ЖДХ	9.9	9.7	9.2	9.6	9.6	8.8	10.0	9.2	8.8
ТБҮЦ-ны ЖДХ	12.1	13.1	13.1	13.0	13.0	13.0	12.6	12.0	12.0
Бодлогын хүү	12.0	13.0	13.0	13.0	13.0	13.0	12.0	12.0	12.0
БХЗ-ын ЖДХ	12.2	13.1	13.2	13.2	13.1	11.8	11.8	11.4	12.6
Инфляци									
Улаанбаатар хотын инфляци									
сарын	0.6	0.2	0.8	0.1	-0.9	-0.2	0.4	0.8	0.3
оны эхнээс	10.7	0.7	1.5	2.6	1.9	1.1	0.4	1.2	1.5
жилийн	10.7	8.5	8.8	7.1	3.9	1.1	1.0	1.6	1.1
Суурь инфляци									
сарын	0.4	0.1	0.1	0.1	0.3	-0.1	-0.4	-0.4	-0.4
оны эхнээс	12.6	0.1	0.5	0.5	3.2	4.8	-0.4	-0.7	-1.1
жилийн	12.6	12.0	11.9	9.6	6.1	4.8	4.0	3.5	3.1
Улсын инфляци									
сарын	0.8	0.4	0.8	-0.1	-0.8	-0.2	0.5	0.7	0.5
оны эхнээс	11.0	1.1	1.9	3.2	2.6	1.9	0.5	1.2	1.7
жилийн	11.0	9.3	9.3	7.3	4.9	1.9	1.7	2.0	1.7

* Төгрөгийн зээлийн жигжээн дундаж хүү

Мөнгөний нийлүүлэлт

Мөнгөний нийлүүлэлт өмнөх сараас 1.0 хувь, өмнөх оны мөн үеэс 2.1 хувиар өсч 10113.7 тэрбум төгрөг болжээ.


Мөнгөний нийлүүлэлтийн 54.1 хувийг төгрөгийн хадгаламж, 20.8 хувийг гадаад валютын хадгаламж, 11.4 хувийг төгрөгийн харилцах, 9.5 хувийг гадаад валютын харилцах, 4.2 хувийг хадгаламжийн байгууллагуудаас гадуурх мөнгө эзэлж байна.



Тайлант сард хадгаламжийн байгууллагуудаас гадуурх мөнгөний жилийн өөрчлөлтийн хурд өмнөх сарынхаас 17.5 нэгж хувь, төгрөгийн харилцахынх 11.9 нэгж хувь, төгрөгийн хадгаламжийнх 5.3 нэгж хувь, гадаад валютын хадгаламжийнх 0.2 нэгж хувиар тус тус өссөн бол гадаад валютын харилцахынх 5.4 нэгж хувиар буурсан байна.

Мөнгөний үзүүлэлтүүдийн сарын өөрчлөлтийг авч үзвэл төгрөгийн хадгаламж 97.0 тэрбум төгрөг, төгрөгийн харилцах 47.7 тэрбум төгрөг, гадаад валютын хадгаламж 37.9 тэрбум төгрөг, хадгаламжийн байгууллагуудаас гадуурх мөнгө 13.1 тэрбум


төгрөгөөр өсч, гадаад валютын харилцах 96.9 тэрбум төгрөгөөр буурчээ.




Мөнгөний нийлүүлэлт өмнөх оны мөн үеэс 2.1 хувиар өссөний 2.8 нэгж хувийг төгрөгийн хадгаламж, 1.0 нэгж хувийг төгрөгийн харилцах, 0.4 нэгж хувийг хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө, -0.8 нэгж хувийг гадаад валютын хадгаламж, -1.3 нэгж хувийг гадаад валютын харилцах тус тус бүрдүүлсэн байна.

Хадгаламж


Нийт хадгаламж өмнөх сараас 1.8 хувь буюу 134.9 тэрбум төгрөгөөр өсч 7572.2 тэрбум төгрөг болов.



Иргэдийн төгрөгийн хадгаламж өмнөх сараас 2.3 хувь буюу 102.9 тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 17.6 хувь буюу 673.2 тэрбум төгрөгөөр өсч 4497.3 тэрбум төгрөгт хүрчээ. Аж ахуйн нэгж, байгууллагуудын төгрөгийн хадгаламж өмнөх сараас 0.6 хувь буюу 6.0 тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 28.9 хувь буюу 393.6 тэрбум төгрөгөөр буурч 970.1 тэрбум төгрөг болжээ.



Гадаад валютын хадгаламж өмнөх сараас 1.8 хувь буюу 37.9 тэрбум төгрөгөөр өсч, өмнөх оны мөн үеэс 3.6 хувь буюу 77.7 тэрбум төгрөгөөр буурч 2104.9 тэрбум төгрөг болжээ.




Нийт хадгаламжийн 72.2 хувь нь төгрөгийн, 27.8 хувь нь валютын хадгаламж байгаа бөгөөд төгрөгийн хадгаламжийн нийт хадгаламжинд эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 1.8 нэгж хувиар өссөн байна.

Мөнгөний нийлүүлэлтийн 11.4 хувийг эзэлж буй төгрөгийн харилцах өмнөх сараас 4.3 хувь буюу 47.7 тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 9.6 хувь буюу 101.4 тэрбум төгрөгөөр өсч 1157.0 тэрбум төгрөг болсон бол 9.5 хувийг эзэлж буй валютын харилцах өмнөх сараас 9.2 хувь буюу 96.9 тэрбум төгрөг, өмнөх оны мөн үеэс 11.9 хувь буюу 129.6 тэрбум төгрөгөөр буурч 957.7 тэрбум төгрөг болжээ.

Гадаад, дотоод цэвэр актив


Гадаад цэвэр актив өмнөх сараас 5.3 хувиар өсч, өмнөх оны мөн үеэс 34.0 хувиар буурснаар -4086.0 тэрбум төгрөгт, дотоод цэвэр актив өмнөх сараас 5.8 хувиар өсч, өмнөх оны мөн үеэс 12.1 хувиар буурч 6027.7 тэрбум төгрөг болов.



Тайлант сард Улсын их хурлын тогтоолын дагуу Төв банкны өмчлөлд байсан 1781.3 тэрбум төгрөгийн орон сууцны зээлээр баталгаажсан үнэт цаасны өмчлөл, 678.9 тэрбум төгрөгийн орон сууцны ипотекийн зээлийг санхүүжүүлэх зориулалтаар банкуудад олгосон зээлийн шаардах эрхийн өмчлөлийг Засгийн газар (Ирээдүйн тэтгэврийн нөөц сан)-т шилжүүлэв. Энэ нь Төв банк болон хадгаламжийн байгууллагуудын тойм дахь Засгийн газраас авах цэвэр авлага тайлант сард 877.1 тэрбум төгрөгөөр буурч 5.6 тэрбум төгрөг болоход гол нөлөө үзүүлэв.

Нөөц мөнгө

Нөөц мөнгө өмнөх сараас 2.3 хувиар өсч, өмнөх оны мөн үеэс мөн 4.4 хувиар буурч 2360.7 тэрбум төгрөг болжээ. Тайлант сард Төв банк дахь харилцах, хадгаламж 3.0 хувь буюу 49.2 тэрбум төгрөг, хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө 3.2 хувь буюу 13.1 тэрбум төгрөгөөр өссөн бол банкуудын касс 4.2 хувь буюу 10.1 тэрбум төгрөгөөр өссөн байна.



Хадгаламжийн байгууллагуудаас гадуурх мөнгөний нөөц мөнгөнд эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 2.3 нэгж хувиар өсч 18.1 хувь, Банкуудын Төв банк дахь харилцах, хадгаламжийнх 0.5 нэгж хувиар өсч 72.2 хувь, банкуудын кассын эзлэх хувь 2.8 нэгж хувиар буурч 9.7 хувьтай байна.

Зээл

Санхүүгийн байгууллагуудын зээлийн үлдэгдлийн жилийн өөрчлөлтийн хурд өмнөх сараас 1.8 нэгж хувиар, өмнөх оны мөн үеэс 14.9 нэгж хувиар буурч жилийн 8.0 хувийн өөрчлөлттэй байна.

Санхүүгийн байгууллагуудаас олгосон зээл өмнөх сарынхаас 1.6 хувь буюу 282.1 тэрбум төгрөг, өнгөрсөн оны мөн үеэс 8.0 хувь буюу 1368.8 тэрбум төгрөгөөр өсч 18.4 их наяд төгрөгт хүрсэн байна. Үүний 64.1 хувь буюу 11.8 их наяд төгрөгийг хадгаламжийн байгууллагуудын, 35.9 хувь буюу 6.6 их наяд төгрөгийг бусад санхүүгийн байгууллагуудын зээл бүрдүүлж байна.

Санхүүгийн байгууллагуудаас иргэдэд олгосон зээл өмнөх сараас 1.9 хувь буюу 137.6 тэрбум төгрөг, өнгөрсөн оны мөн үеэс 7.1 хувь буюу 485.8 тэрбум төгрөгөөр өсч 7285.7 тэрбум төгрөгт, хувийн хэвшилд олгосон зээл өмнөх сараас 0.9 хувь буюу 63.8 тэрбум төгрөгөөр өсч, өнгөрсөн оны мөн үеэс 0.2 хувь

буюу 17.4 тэрбум төгрөгөөр буурч 7144.0 тэрбум төгрөг болжээ.



Санхүүгийн байгууллагуудын нийт зээлийг өмчлөгчөөр нь авч үзвэл 39.5 хувь нь иргэд, 38.7 хувь нь хувийн хэвшил, 21.7 хувь нь улсын байгууллага, 0.1 хувь нь бусад байгууллагад олгосон зээл байна.




Нийт зээлийн үлдэгдлийн 86.2 хувийг хэвийн зээл, 8.5 хувийг хугацаа хэтэрсэн зээл, 5.2 хувийг чанаргүй зээл тус тус эзлэв. Нийт зээлд эзлэх хугацаа хэтэрсэн зээлийн эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 4.2 нэгж хувь, чанаргүй зээлийнх 1.1 нэгж хувиар өссөн байна.

Хадгаламжийн байгууллагуудын зээлд чанаргүй зээлийн эзлэх хувь 8.2 хувь байгаа бөгөөд татан буугдсан банкуудын мэдээллийг хасч тооцвол чанаргүй зээл 6.3 хувийг эзэлж байна.

Картын зээл

Банкуудаас иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудад олгосон картын зээлийн үлдэгдэл нийт банкны салбарын зээлийн үлдэгдлийн 1.8 хувийг бүрдүүлж байна.

Картын зээл 3 дугаар сарын байдлаар 212.9 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 13.9 хувиар буюу 34.4 тэрбум төгрөгөөр буурчээ. Картын зээлийн дийлэнхийг иргэдэд олгосон байгаа бөгөөд өмнөх сараас 1.3 хувиар буюу 2.9 тэрбум төгрөгөөр буурсан байна.



Картын зээлийн 90.1 хувь нь хэвийн, 2.9 хувь нь хугацаа хэтэрсэн, 7 хувь нь чанаргүй гэж ангилагджээ. Картын зээлийн 92.8 хувь нь төгрөгөөр, 7.2 хувь нь валютаар олгогдсон байна.

Хүү

Төв банкны үнэт цаасны жигнэсэн дундаж хүү 2016 оны 3 дугаар сард өмнөх оны мөн үеэс 1.0

нэгж хувиар буурч жилийн 12.0 хувь болов. Банкуудын тухайн сард олгосон төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү өнгөрсөн оны мөн үеэс 0.6 нэгж хувиар өсч жилийн 19.7¹ хувь, гадаад валютынх өмнөх оны мөн үеэс 0.7 нэгж хувиар өсч жилийн 12.4 хувь болжээ.




Төгрөгийн болон гадаад валютын харилцахын хүү харьцангуй тогтвортой байна. Төгрөгийн хадгаламжийн жигнэсэн дундаж хүү өмнөх оны мөн үеэс 0.4 нэгж хувиар өсч жилийн 13.3 хувь, валютын хадгаламжийн жигнэсэн дундаж хүү өмнөх оны мөн үеэс 0.6 нэгж хувиар өсч жилийн 6.6 хувь болов.

Мөнгөний зах

2016 оны 3 дугаар сард банк хоорондын захын арилжаагаар нийт 162.1 тэрбум төгрөгийн гүйлгээ хийгджээ. Эдгээр арилжааны жигнэсэн дундаж хүү жилийн 12.55 хувь байна.

¹ Банкуудын тухайн сард олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү нь Монголбанкны үнэ тогтворжуулах хөтөлбөрийн (ҮТХ) зээлийг оруулахгүй тооцсон хүү болно. Харин ҮТХ-ийн зээлийг оруулан тооцвол



2016 оны 3 сарын 2-ны өдрөөс 2016 оны 3 сарын 29-ний өдрийн хугацаанд банкууд төгрөгийн заавал байлгах нөөцөд дунджаар 963.3 тэрбум төгрөг, валютын заавал байлгах нөөцөд дунджаар 433.6 тэрбум төгрөг байлгах шаардлагыг хангаж ажиллав. Банкууд төгрөгийн заавал байлгах нөөцөд дунджаар 914.4 тэрбум төгрөг, валютын нөөцөд дунджаар 735.8 тэрбум төгрөг тус тус төвлөрүүлсэн байна.

Валютын ханш

Төгрөгийн ам.доллартай харьцах ханш 2016 оны 3 дугаар сарын эцэст 2048.9 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 64 төгрөгөөр суларсан байна. Тайлант сард төгрөгийн ам.доллартай харьцах дундаж ханш 2046.35 төгрөг байв.

Тайлант сарын эцэст төгрөгийн евротой харьцах ханш 2322.2, хятадын юаньтай

төгрөгийн жигнэсэн дундаж хүү тайлант сард 17.9 хувь байна.

харьцах ханш 316.86, японы иентэй харьцах ханш 18.23 төгрөг болжээ.

Инфляци

Хэрэглээний үнийн улсын индекс 2016 оны 3 дугаар сарын эцэст өмнөх сараас 0.5 хувь, оны эхнээс болон өмнөх оны мөн үеэс 1.7 хувиар өссөн бол Улаанбаатар хотын хэрэглээний үнийн индекс өмнөх сараас 0.3 хувь, оны эхнээс 1.5 хувь, өмнөх оны мөн үеэс 1.1 хувиар өсчээ. Суурь инфляци тухайн сард -0.4 хувь, оны эхнээс -1.1, жилийн 3.1 хувьтай байв.

Тухайн сард Улаанбаатар хотод мах, махан бүтээгдэхүүний үнэ 5.4 хувь, хүнсний ногооны үнэ 2.9 хувь, сүү, сүүн бүтээгдэхүүний үнэ 0.4 хувь, жимсний үнэ 0.4 хувиар өсч, өөх тосны үнэ 0.9 хувь, чихэр, шоколадны үнэ 0.6 хувь, талх, гурил, будааны үнэ 0.2 хувиар буурснаар хүнсний барааны бүлгийн үнэ 2.2 хувиар өссөн байна.

Хүнснээс бусад бараа, үйлчилгээний үнэ 0.4 хувиар буурсан нь нүүрсний үнэ 7.1 хувь, хувцас, гуталны үнэ 0.8 хувь, гэр ахуйн барааны үнэ 0.7 хувиар буурч, тамхины үнэ 4.2 хувиар өссөнтэй холбоотой. Мөн телефон, факсын хэрэгслийн үнэ 9.6 хувиар өссөн байна.



Боловсролын бүлгийн **жилийн инфляци** 23.6 хувь (*жилийн өсөлтийн 152.9 хувь*), эм, тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийнх 8.2 хувь (*жилийн өсөлтийн 21.3 хувь*), гэр ахуйн тавилга, барааны бүлгийнх 4.0 хувь (*жилийн өсөлтийн 11.4 хувь*), согтууруулах ундаа, тамхины бүлгийнх 2.1 хувь (*жилийн өсөлтийн 8.7 хувь*), хувцас, бөс бараа, гутлын бүлгийнх 1.1 хувь (*жилийн өсөлтийн 12.9 хувь*), зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний бүлгийнх 1.8 хувиар (*жилийн өсөлтийн 5.6 хувь*), тус тус өссөн байна. Харин хүнсний барааны үнэ 3.0 хувь (*жилийн өсөлтийн -80.4 хувь*), тээврийн бүлгийн үнэ 2.6 хувь (*жилийн өсөлтийн -25.0 хувь*), орон сууц, цахилгаан, түлшний бүлгийн үнэ 1.4 хувиар (*жилийн өсөлтийн -18.1 хувь*) буурсан байна.

Хүнсний барааны бүлгийг задалж үзвэл, 0.3 нэгж хувийг талх, гурил, будаа, 0.1 нэгж хувийг хүнсний ногоо, -0.2 нэгж хувийг сүү, өндөг, -1.3 нэгж хувийг мах, махан бүтээгдэхүүний үнийн өөрчлөлт бүрдүүлсэн байна.